



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот


Хан-Уул дүүргийн “Амгалан-Өрх” өрхийн
эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 32,626,392.0 /гучин хоёр сая зургаан зуун хорин зургаан мянга гурван зуун ерэн хоёр төгрөг/ бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Амгалан-Өрх” өрхийн эрүүл мэндийн төв /Ц.Энхтуяа/-д зөвшөөрсүгэй.
2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 17 нэр төрлийн 3,609,866.0 /гурван сая зургаан зуун есөн мянга найман зуун жаран зургаан/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 59 нэр төрлийн 29,016,526.0 /хорин есөн сая арван зургаан мянга таван зуун хорин зургаан төгрөг/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Амгалан-Өрх” өрхийн эрүүл мэндийн төв /Ц.Энхтуяа/-д үүрэг болгосугай.
3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001309